



## ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 06 сарын 13 өдөр

Дугаар A/228

Улаанбаатар хот

Г Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн  
орон тооны бус зөвлөлийн ажиллах журам батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4, 30.1.13, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай 27 дугаар зүйлийн 27.2-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Онцгой байдлын байгууллагын “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус зөвлөлийн ажиллах журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга, захирагч наарт үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллахыг ажиллахыг Дэд дарга (хурандаа Ц.Уранчимэг)-д даалгасугай.
4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2020 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн “Журам батлах тухай” А/99 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.


ДАРГА,  
ХОШУУЧ ГЕНЕРАЛ

Г.АРИУНБУЯН



1425011762

Онцгой байдлын ерөнхий газрын даргын  
2025 оны 06 дугаар сарын 01-ны өдрийн  
тушаалын хавсралт



## ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ОРОН ТООНЫ БУС ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Онцгой байдлын байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус зөвлөл, салбар зөвлөлийн (цаашид Зөвлөл гэх) үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Онцгой байдлын байгууллагын хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулж, эрүүл аюулгүй ажлын орчныг бий болгох, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчинеэс урьдчилан сэргийлэх, холбогдох хууль, дүрэм, журам, стандартын хэрэгжилтийг хангуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.3. Зөвлөл нь хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөөг хангах, хараат бус байх зарчмыг баримтална.

### Хоёр. Зөвлөлийн бүрэлдэхүүн

2.1. Онцгой байдлын ерөнхий газар нь газар, хэлтсийн дарга, ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн нараас бүрдсэн 9-15 хүний бүрэлдэхүүнтэй орон тооны бус зөвлөлтэй байна.

2.2. Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх анги, байгууллага, төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтэс нь бүтэц, орон тооноос хамааран удирдлагын бүрэлдэхүүн, алба хаагчийг оролцуулсан 3-7 хүний бүрэлдэхүүнтэй орон тооны бус зөвлөлтэй байна.

2.3. Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын газар, хэлтсийн анги, салбар нь бүтэц, орон тооноос хамаар ан удирдлагын болон алба хаагчийг хамруулсан 3-5 хүний бүрэлдэхүүнтэй салбар зөвлөлтэй байна.

*Тайлбар: Алслагдсан сум, суурин тосгонд үйл ажиллагаа явуулж буй 20-с доош орон тоотой нэгжийн үйл ажиллагааг тухайн аймгийн Онцгой байдлын газрын зөвлөл хариуцна.*

### Гурав. Үйл ажиллагааны зохион байгуулалт

3.1. Зөвлөлийн үйл ажиллагааны хэлбэр нь хурал байх бөгөөд улиралд нэгээс доошгүй удаа хуралдана.

3.2. Нийт гишүүдийн ирц 60 ба түүнээс дээш хувийн ирцтэй үед хурлыг зохион байгуулна.

3.3. Зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан тухайн газар, хэлтэс, анги, салбарын холбогдох алба хаагчийг хуралд оролцуулж болно.

3.4. Зөвлөл нь тухайн жилд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлуулж, үйл ажиллагааны хэрэгжилт, хэрэгжүүлсэн ажил арга хэмжээний талаар удирдлага болон бие бүрэлдэхүүнд тайлагнана.

3.5.Журмын 2.3-д заасан салбар зөвлөл нь үйл ажиллагааны тайлан, мэдээг улирал, хагас, бүтэн жилээр гаргаж, 2.2-д заасан зөвлөлд, журмын 2.2-д заасан зөвлөл нь тайлан мэдээг нэгтгэж Онцгой байдлын ерөнхий газрын хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй хариуцсан зөвлөлд ирүүлнэ.

3.6.Онцгой байдлын ерөнхий газрын зөвлөл нь тайлан, мэдээг нэгтгэж, жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны дотор Онцгой байдлын ерөнхий газрын даргад танилцуулна.

#### Дөрөв. Зөвлөл, салбар зөвлөлийн чиг үүрэг

4.1.Орон тооны бус зөвлөл, салбар зөвлөл нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

4.1.1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, түүнд нийцүүлэн гарсан дүрэм, журмын хэрэгжилтийг байгууллагын түвшинд хангуулж, хяналт тавих, хөдөлмөр зохион байгуулалтыг сайжруулах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежмент, шинэ техник, технологи, инновацыг үйл ажиллагаандaa нэвтрүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;

4.1.2.Байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хөтөлбөр төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбоотой зардлын тооцооллыг гаргаж, төсөвт тусгуулах талаар санал гаргах, шаардлагатай дүрэм, журмыг боловсруулж, мөрдүүлэх;

4.1.3.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний шалтгаан нөхцөлийн талаар хэлэлцэх, санал, зөвлөмж гаргах;

4.1.4.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн аян, сургалт, зөвлөгөөн зохион байгуулах;

4.1.5.Ажлын байрны эрсдэлийн үнэлгээг тухайн мэргэжлийн албан тушаалтныг оролцуулж хийх, бүртгэл судалгаатай танилцаж, осолд дөхсөн тохиолдлыг илрүүлж, эрсдэлийг бууруулах зөвлөмж өгч ажиллах;

4.1.6.Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлд үнэлгээ хийлгэх, дүнг удирдлага, нийт алба хаагчдад мэдээлэх;

4.1.7.Ажлын байрны орчин нөхцөл, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт, эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан байдал, түүний мөрөөр хийгдсэн эмчилгээ, сувилгаатай танилцах, хоолны чанарт хяналт тавьж, үр дүнг тооцож танилцуулах;

4.1.8.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл, салбар зөвлөл, Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус комиссын гишүүдийг чадавхжуулах арга хэмжээг зохион байгуулах, шаардлагатай зардлыг шийдвэрлүүлэх;

4.1.9.Ажлын төлөвлөгөө боловсруулж тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах, алба хаагчийн эрүүл мэнд, нийгмийн баталгааг хангуулах талаар санал, санаачилга гаргаж ажиллах;

4.1.10.Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх комиссын үйл ажиллагаанд хяналт тавьж, дэмжлэг үзүүлэх, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах;

4.1.11.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар алба хаагч, ажилтны дэвшүүлсэн оновчтой санал, санаачилгыг хүлээн авах, саналыг удирдлагад хүргүүлэх;

4.1.12.Хууль тогтоомжид заасан бусад холбогдох асуудлыг хэрэгжүүлэх.

#### Тав. Зөвлөл, салбар зөвлөлийн эрх

5.1.Орон тооны бус зөвлөл, салбар зөвлөл нь дараах эрхийг хэрэгжүүлнэ:

5.1.2Байгууллагын удирдлагад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, ажлын байрны нөхцөлийг сайжруулах, гарч болзошгүй осол, эндэгдэл, өвчлөлөөс сэргийлэх арга хэмжээ авах талаар танилцуулга, зөвлөмж хүргүүлэх;

5.1.3.Холбогдох стандартын шаардлагад нийцсэн хамгаалах тусгай хувцас, хүн нэг бүрийн хамгаалах хэрэгслийн нөхөн хангарт, хэрэглээ, чанарт хяналт тавьж, нөхөн хангалтыг нэмэгдүүлэх талаар санал хүргүүлэх;

5.1.4.Байгууллагын удирдлагад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлийг бий болгох, сайжруулахад идэвх санаачилгатай ажилласан алба хаагч, зөвлөлийн гишүүдийг урамшуулах санал гаргах;

5.1.5.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль, стандарт, дүрэм, журмыг зөрчсөн албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх талаар санал гаргах.

#### Зургаа. Хариуцлага

6.1.Төв, орон нутгийн байгууллагын зөвлөл, салбар зөвлөлийн үйл ажиллагаанд Онцгой байдлын ерөнхий газрын орон тооны бус зөвлөл, Хяналт, шинжилгээ, үнэлгээний асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

6.2.Энэхүү журмыг зөрчсөн албан тушаалтанд холбогдох хууль, дүрмийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---оОо---